1.15.5. Ашигт малтмалын нөөцийг бүртгэсэн төрийн захиргааны байгууллагын даргын тушаал, шийдвэрийг үндэслэн мэдээллийн сангийн нөөцийн дэд санд бүртгэх, 2010-2013 оны металл ашигт малтмалын нөөцийн баланс гаргах, нөөцтэй холбоотой мэдээ тайлан гаргах.	Тоо хэмжээ – 3 ажил үйлчилгээ 130 орд бүртгэх, металл а/м-ын 14 төрөл. Хугацаа – жилдээ, Чанар –Нөөцийн зааврын дагуу, үнэн зөв бэлтгэх	<p>1. Мэдээллийн сангийн нөөцийн дэд санд 135 ордын нөөцийн мэдээллийг 25 асуултаар шинээр бүртгэв. (тайлан дугаар 7550-7798).</p> <p>2. Даргын тушаал шийдвэрийг үндэслэн 1990-2009 онуудад олборлосон 102 ордын нөөцийн хөдөлгөөнийг мэдээллийн сангийн нөөцийн дэд санд бүртгэв. Үүнд: Төмөр-16, алтны үндсэн-10, мөнгө-2, зэс-молибден-1, цайр-2, хар тугалга-2, кадми-2, вольфрам, цагаан тугалга-7, хайлуур жонш 32, гөлтгөнө-2, цементын түүхий эд-6, элс-хайрга-15, шохойн чулуу-9, өнгөлгөөний чулуу-1, тоосгоны шавар-9, балластын түүхий эд-1, барилгын чулуу-6, давс-2, цеолит-1 3.2005-2009 онуудад олборлосон Au, Ag, Cu, Mo, Fe, Pb, Zn, Cd, Sr, W, Sn-зэрэг ашигт малтмалын нөөцийн хөдөлгөөний балансын тайлбар, дүгнэлтийг хийж, хянуулах, улмаар Геологи мэдээллийн төв архивт тушаах ажил үргэлжилж байна.</p> <p>4. Нүүрсний 12 ордын 1962-2013 онуудад олборлосон нөөцийн хөдөлгөөнийг нөөцийн улсын нэгдсэн санд оруулав.</p> <p>5. Нөөцийн бүртгэлийн таамаг нөөцийн дэд санд шинээр 9 орд, 192 илрэл, дагалдах ашигт малтмалын 158, нийтдээ 250 илрэлийн нөөцийн мэдээллийг шинээр бүртгэв.</p>	
1.15.6. Чулууны дээжний хадгалалтыг сайжруулах, цэгцлэх өмнө өгч байсан үүргийн хүрээнд 2014 онд хийсэн ажлын тайланг Уул уурхайн яаманд танилцуулах	Тоо хэмжээ:1 танилцуулга, Хугацаа: I улирал, Чанар: Үнэн бодитой, хэрэгжихүйц	Чулууны дээжний хадгалалтыг сайжруулах зорилгоор сангийн байрыг цэгцлэж, 2014 онд хийсэн ажлын тайлан, цаашид хийх ажлын төлөвлөгөөний хамт Уул уурхайн яаманд танилцуулан, хүргүүлсэн болно.	
1.15.7. Цуцлагдсан тусгай зөвшөөрлүүдийн тайлан, төлөвлөгөөг ил болгох боломжийг судлах	Тоо хэмжээ:1 санал, Хугацаа: I-II улирал, Чанар: Үнэн бодитой, хэрэгжихүйц	Цуцлагдсан тусгай зөвшөөрлүүдийн тайлан, төлөвлөгөөг ил болгох боломжийг судлах ажлыг хуулийн хэлтэстэй хамтран санал боловсруулсан. АМТХ, Хувь хүний нууцын тухай хууль, Компаний тухай хууль, Архивын тухай хууль болон батлагдсан дүрэм, журам тогтоомжийн хүрээнд ажиллах зөвлөмж өгсөн.	
<b>1.16. Геологийн судалгааг мэргэшсэн инженер, техникийн ажилтнаас бүрдсэн багийн мэдлэг, туршлагад түшиглэж, нутаг дэвсгэрийн геологийн тогтоцын онцлогт тохирсон оновчтой арга, аргачлал, дэвшилтэт техник, технологиор гүйцэтгүүлж, геологийн судалгаа, эрэл, хайгуулын ажлын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх</b>			

<p>1.16.1. Геологийн салбарын боловсон хүчний судалгааг мэргэжил тус бүрээр болон зөвлөх, мэргэшсэн инженерүүдийн нарийвчилсан судалгааг гаргах, дүн шинжилгээ хийж эхлэх</p>	<p>Тоо хэмжээ:1 судалгаа, Хугацаа: жилдээ, Чанар: Үнэн бодитой, шуурхай</p>	<p>Геологийн салбарын боловсон хүчний судалгааг мэргэжил тус бүрээр болон зөвлөх, мэргэшсэн инженерүүдийн нарийвчилсан судалгааг гаргаж нэгтгэн УУЯ-ны ХШҮДАГ-Т 2015.01.22-ны 4/306 албан тоотой явуулсан. УТХ-өөр хийсэн геологийн судалгааны ажлын болон хувийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын тайлан, мэдээ, ШУТИС-аас авсан мэдээнд тулгуурлан Монгол улсад геологийн салбарын чиглэлээр зөвлөх, мэргэшсэн геологчдийн судалгааг гаргасан. Зөвлөх-52, мэргэшсэн инженер-139 байна.</p>	
<p>1.16.2. УТХ-өөр болон хувийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил гүйцэтгэгч байгууллагууд, тэдгээрийн боловсон хүчний судалгааг гаргах, дүн шинжилгээ хийж эхлэх</p>	<p>Тоо хэмжээ:1 судалгаа, Хугацаа: жилдээ, Чанар: Үнэн бодитой, шуурхай</p>	<p>УТХ-өөр геологийн судалгааны ажил гүйцэтгэгч байгууллагууд, тэдгээрийн боловсон хүчний судалгааг гаргах, дүн шинжилгээ хийх ажлыг нэгтгэсэн. Өнөөдрийн байдлаар 726 орчим хүн улсын төсвийн хөрөнгийн гүйцэтгэж байгаа ажилд ажиллаж байна. Хувийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын жил болгоны төлөвлөгөө, тайлан, мэдээ, КХ-ийн бүртгэлд тулгуурлан судалгаа гаргасан. Хувийн хөрөнгөөр хайгуулын ажлыг 1000 орчим ААН хийж түүнд нийт 13400 орчим хүн ажилладагас 6700 байнгын орон тоонд ажилладаг, бусад нь улирлын чанартай ажил эрхэлдэг байна.</p>	
<p>1.16.3. Геофизик, өрөмдлөгийн багаж, тоног төхөөрөмж, геологийн програм хангамж зэргийн судалгааг гаргах, дүн шинжилгээ хийж эхлэх</p>	<p>Тоо хэмжээ:1 судалгаа, Хугацаа: жилдээ, Чанар: Үнэн бодитой, шуурхай</p>	<p>Геофизик өрөмдлөгийн багаж, тоног төхөөрөмж, геологийн программ хангамж зэргийн судалгааг гаргасан. 40 ААН геофизикийн чиглэлээр багаж төхөөрөмжтэй ба улирлын чанартай ажиллагсдыг оролцуулаад 500 орчим ажиллаж байна. Өрөмдлөгийн ажлын тоног төхөөрөмжийн талаарх судалгаагаар өрөмдлөгийн ажил гүйцэтгэдэг дотоод гадаадын 20 гаруй компани, олон тооны хувь хүмүүс үйл ажиллагаа явуулж, өрөмдлөгийн 100 орчим төхөөрөмж ажиллаж байна. Өрөмдлөгийн төхөөрөмжүүдийг зориулалтаар геологи-хайгуулын баганат өрөмдлөгийн төхөөрөмж - 47%, усны эрэл хайгуул, ашиглалтын өрөмдлөгийг 37%, газрын тосны гүний өрөмдлөгийн 5%, инженер хайгуулын, тэсэлгээний зэрэг техникийн зориулалттай өрөмдлөгийг 11% тус тус ажиллаж байна Үйлдвэрлэсэн улс орноор нь ангилж үзвэл ОХУ-ын 40%, Солонгосын 9%, Австрали, Канад, Япон - 22%, бусад орных – 29% тус тус байна.</p>	

<p>1.16.4. УТХ-өөр гүйцэтгэж буй төслүүдийн геологич нарт геологичдыг мэдлэг чадварыг дээшлүүлэх, тэднийг чадваржуулах зорилгоор сургалтыг геологийн мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах</p>	<p>Тоо хэмжээ –1 арга хэмжээ Хугацаа - жилдээ Чанар – Зохих мэдлэг олгосон байна</p>	<p>УТХ-өөр гүйцэтгэж буй төслүүдийн геологич нарт геологичдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, тэднийг чадваржуулах зорилгоор сургалтыг “Улаанбаатар дүүргийн геологийн сонгомол бүтцүүдийн тогтоц” сэдэвт экскурс, геологийн ажил мэргэжлийн уралдааныг 2015 оны 10-р сарын 13-14-ний өдрүүдэд зохион байгуулав. Хээрийн судалгааны экскурсд багш Д.Чулуун, С.Хишигсүрэн, Г.Ээнжин, Т.Оюунчимэг нар оролцож залуу геологич нарт лекц хийв. Ажил мэргэжлийн уралдааныг Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг Тогостойн ам гэдэг газар зохион байгуулсан бөгөөд уг уралдаанд нийт 11 баг оролцсон.</p>	
<p><b>1.17. Цацраг идэвхт ашигт малтмалын чиглэлээр Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд гүйцэтгэж байгаа бүх төрлийн геологийн судалгааны ажлуудын үр дүнг нэгтгэж, олон улсын жишигт хүрсэн, стандартын шаардлагад нийцсэн, үндэсний мэдээллийн санг бүрдүүлнэ.</b> <b>/ЗГҮАХХТ-43.8-р заалт/</b></p>			
<p>Цацраг идэвхт ашигт малтмалын чиглэлээр Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд гүйцэтгэж байгаа бүх төрлийн геологийн судалгааны ажлуудын үр дүнг нэгтгэж, олон улсын жишигт хүрсэн, стандартын шаардлагад нийцсэн, үндэсний мэдээллийн санг бүрдүүлэх чиглэлээр МУИС, ШУТИС-тай хамтран ажиллана.</p>	<p>Тоо хэмжээ –1 ажил үйлчилгээ Хугацаа - жилдээ Чанар – Шаардлагатай мэдээллийг бүрэн хамарсан байна</p>	<p>Цацраг идэвхт ашигт малтмалын чиглэлээр хийгдсэн материалуудыг ЦЭГ-аас хүлээн авч Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд гүйцэтгэж байгаа геологийн судалгааны ажлуудаар санд үүсгэж бүрдүүлсэн. ЦЭГ-аас 257 хавтастай тайлан, төлөвлөгөөг хүлээн авч акт үйлдсэн Цөмийн Энергийн Газраас шилжүүлсэн тусгай зөвшөөрөл тус бүрээр 2012 оны 38, 2013 онд нийт 39 жилийн тайлан дээр үндэслэн гүйцэтгэсэн хайгуулын ажлын талаар дэлгэрэнгүйгээр санд бүртгэсэн. Уул уурхайн яамны сайдын 214-р тушаалын дагуу Дорнод аймгийн Дашбалбар сумын Дорнодын ураны ордын судалгааны ажлын тайлан холбогдох материалыг хүлээн авч ГМТА-н санд бүртгэсэн. Цацраг идэвхит ашигт малтмалын ордууд, нөөц, сүүлийн 3 жилийн хугацаанд хийсэн хайгуулын ажлын талаар ажлын төрөл, зардлаар төрөлжсөн судалгаа хийж Цөмийн Энергийн Комисс 1/2696 тоотоор мөн 1/2697 тоотоор УУЯ-нд хүргүүлсэн Цөмийн Энергийн Комиссоос мэдээлэл хүсэх тухай 1/52 тоот албан тоотын дагуу сар бүр Цацраг идэвхит ашигт малтмалын нийт нөөцийн мэдээг шинэчлэн гаргаж өгч байна.</p>	

<b>Хоёр. "Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уул уурхайн салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах, бодлогын удирдамжийг нь хэрэгжүүлэх, энэ салбарт хөрөнгө оруулалтын орчинд үнэлэлт, дүгнэлт өгөх, түүнийг сайжруулах санал, судалгаа боловсруулах" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</b>		
<b>2.1.Татварын зохицуулалт хийх замаар түүхийгээр гаргаж байгаа уул уурхайн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлнэ /ЗГҮАМХ – 40.7-р заалт/</b>		
2.1.1. Судалгаанд үндэслэн татварын зохицуулалтын санал боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлэх	Тоо - 1 санал, 2 арга хэмжээ Чанар - Үндэслэл сайтай, хэрэгжихүйц бодитой Хугацаа: 1-2 улиралд	Боловсруулах үйлдвэрлэлийг татварын зохицуулалтаар дэмжих бодлогын хүрээнд шаардлагатай материал цуглуулан татварын орчны судалгаа хийж, санал боловсруулсан. УУЯ болон холбогдох байгууллагад хүргүүлэхээр бэлтгэж байна.
<b>2.2. Уул уурхайн олборлох үйлдвэрийн бүтээгдэхүүнийг зах зээлийн үнээр тэргүүн ээлжинд дотоодын боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлдэг болно. / ЗГҮАХХАХТ -40.8-р/</b>		
2.2.1. Импортын бүтээгдэхүүнийг орлох дотоодын уурхайнуудын бүтээгдэхүүн нийлүүлэлтийн боломжийн судалгаа хийх. санал боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлэх.	Тоо- 1 судалгаа, 1 санал Чанар- Үндэслэл сайтай, Хугацаа: 1-4 улиралд	Импортын бүтээгдэхүүнийг орлох дотоодын уурхайнуудын бүтээгдэхүүнийг судлан Гаалийн Ерөнхий газрын экспорт импортын мэдээлэл дээр суурьлан импортыг орлох бүтээгдэхүүний жагсаалт гаргасан, үүнд үндэслэн нөөц болон түүхий эдийн зориулалтаар нь ялган, нийлүүлэлтийн судалгааг хийж гүйцэтгэлээ.
<b>2.3. Байгаль орчны аудитаар дамжуулж уул уурхайн үйлдвэрлэлд байгаль орчинд сөрөг нөлөөлөл ихтэй технологийг ашиглуулахгүй байх арга хэмжээг авна. /ЗГҮАМХ-40.10-р заалт/</b>		
2.3.1. Байгаль орчны аудит хийж байгаа байгууллагуудтай хамтран ажиллаж, холбогдох мэдээллээр хангах.	Тоо- Шаардлагатай тоо хэмжээгээр Чанар- Үндэслэл сайтай Хугацаа: 1-4 улиралд	1. Техник, технологи, эдийн засгийн тооцоонд өөрчлөлт орсны улмаас ТЭЗҮ-д нэмэлт тодотгол хийсэн 22 аж ахуйн нэгжийн БОНБНҮ-г шинэчлэн батлуулах тухай мэдээллийг БОНХАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын мэргэжилтэн Б.Бүнчинжавт цахимаар хүргүүлсэн. Дээрх аж ахуйн нэгжүүдээс байгаль орчны аудит хийлгэх шаардлагатай аж ахуйн нэгжийн эвдрэлд орсон болон нөхөн сэргээлт хийсэн талбайн мэдээллийг цаг тухай бүр хүргүүлэн ажиллав. 2. Үндэсний аудитын газар “Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүн”-д аудит хийхэд түүнд шаардлагатай 2013-2015 онуудад уулын ажлын төлөвлөгөө тайлан ирүүлсэн аж ахуйн нэгжүүдийн уулын ажилд хамрагдсан талбайн хэмжээ, нөхөн сэргээсэн талбайн хэмжээ, түүнд зарцуулсан зардал, орхигдсон газрын тооллого зэрэг мэдээллийг

		2015 оны 9 дүгээр сарын 23-ны 2/7386 тоотор хүргүүлэв.	
<b>2.4. Ашигт малтмалын төрөл, олборлох, боловсруулах технологийн онцлогийг тусгасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх Европын Холбооны стандартыг нутагшуулж мөрдүүлнэ.</b> <b>/ЗГҮАМХ-40.12-р заалт/</b>			
2.4.1. Холбогдох стандарт, аргачлал, журмын төслийг боловсруулах ажлын хэсэгт орж саналаа өгч ажиллах,	Тоо - Шаардлагатай тоо хэмжээгээр Чанар - Үр дүнд суурилсан үндэслэл сайтай Хугацаа: 1-2 улиралд	1. Германы хамтын ажиллагааны байгууллагын санхүүжилтээр зохион байгуулсан “Байгаль орчинд учруулсан хохирол тооцох аргачлалын шинэчлэсэн төсөл батлуулах” ажлын хэсгийн 4 удаагийн хуралд оролцон дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Уулын ажлын төлөвлөгөө, тайлангаас эвдрэлд орсон болон нөхөн сэргээлт хийсэн талбайн мэдээллийг гаргаж өгөв.</li> <li>• “Уул уурхайн салбарын байгаль орчны эрх зүйн өнөөгийн байдал” сэдвээр илтгэл бэлтгэн ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлээ.</li> </ul> 2. Байгаль орчинд учруулсан хохирол тооцох аргачлалын шинэчилсэн төсөл боловсруулах ажлын хэсэгт орж ажиллан уг төсөлд санал хүргүүлсэн. Аргачлал батлагдсан бөгөөд тушаал гараагүй байна.	
<b>2.5. Нэгдмэл тогтоцтой ордыг иж бүрэн ашиглах, байгальд ээлтэй технологийг судалж нэвтрүүлэхийг дэмжинэ.</b> <b>/ЗГҮАМХ-40.15-р заалт/</b>			
2.5.1. Холбогдох судалгаануудыг нэгтгэх, ажлын хэсгүүдэд орж ажиллах, мэдээллээр хангах.	Тоо - шаардлагатай тоо хэмжээгээр, 1 санал Чанар - Бодитой, үндэслэл сайтай, хууль, журмын дагуу Хугацаа: 1-4 улиралд	1. Дархан, Сэлэнгэ аймгуудын нутагт байрлах төмрийн хүдрийн ордуудыг түшиглэн орчин үеийн техник, технологи бүхий иж бүрэн технологийн цогцолбор бий болгох төслийн цар хүрээний ерөнхий судалгааг хийв. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Судалгааны ажилд шаардлагатай мэдээллийг хүссэн 1/8887 тоот албан бичгийг Эрчим хүчний яам, Зам тээврийн яам, Монголын төмөр зам ТӨХК-нд хүргүүлэн холбогдох мэдээллийг авч нэгтгэв.</li> <li>• Дархан, Сэлэнгийн бүс нутгийн төмрийн хүдрийн ордын нэгдсэн судалгааг гаргаж дуусаад байна. Мөн улсын хэмжээнд төмрийн хүдрийн ордуудын талаарх судалгааг нэгтгэж бэлтгэв.</li> <li>• Дархан, Сэлэнгийн бүс нутгийн төмрийн хүдрийн ордын цахилгаан хангамжийг сайжруулах ажлын хүрээнд хийгдсэн төслүүдийн талаарх мэдээллийг нэгтгэж судалгаа хийв. /Хуудас 5/</li> <li>• Төмөртолгой болон Төмөртэйн төмрийн хүдрийн ордыг</li> </ul>	

		<p>ашиглах ТЭЗҮ-тэй танилцаж, уурхай, баяжуулах, боловсруулах үйлдвэр, дэд бүтцийн талаарх судалгааг гаргасан.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Дархан, Сэлэнгийн бүс нутгийн төмрийн хүдрийн ордыг ашиглах ТЭЗҮ, тайлан, төлөвлөгөөтэй танилцаж ашиглалт, баяжуулалтын технологи, дэд бүтэц, эдийн засгийн тоон үзүүлэлт, хэтийн төлвийн холбогдох суурь судалгааг авсан.</li> </ul> <p>2. Нэгдмэл тогтоцтой ордуудын технологийн шийдэл, дэд бүтцийн асуудал, Засгийн газар хоорондын гэрээ хэлцэл, хэтийн төлвийн талаар нэгтгэсэн судалгааг хийв. /Хуудас 14/.</p>	
<p><b>2.6. Ашигт малтмалыг экспортод гаргахтай холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлж, эрдэс баялгийн экспортыг нэгдсэн “Нэг цонх”-ны бодлогоор хэрэгжүүлэх арга хэмжээ авна. /ЗГҮАМХ-41-р заалт/</b></p>			
<p>2.6.1. Ашигт малтмалыг экспортод гаргахтай холбоотой мэдээлэлээр холбогдох ажлын хэсэг, байгууллагыг хангаж ажиллана.</p>	<p>Тоо - шаардлагатай тоо хэмжээгээр Чанар - Бодитой, үндэслэл сайтай, хууль, журмын дагуу Хугацаа: 1-4 улиралд</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Ашигт Малтмал, Газрын Тосны Хэрэг Эрхлэх газрын дарга, Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын даргын хамтран баталсан 2007 оны 471/816 дугаар тушаалын дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдээс ирүүлсэн 2015 оны уулын ажлын төлөвлөгөөнд үндэслэн улсын хилээр бүтээгдэхүүн экспортлох ААН-үүдийн мэдээллийг боловсруулан Гаалийн ерөнхий газарт хүргүүлсэн.</li> <li>- Улсын хилээр гадаргуун болон гүний усны шинжилгээ, баяжуулалт, хагас үйлдвэрлэл, технологийн туршилтын зориулалтаар дээж нэвтрүүлэх тухай <b>174-н</b> тодорхойлолтыг журмын дагуу ААН-ийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, орд газрын шинжилгээ, судалгаа хийлгэх шаардлага зэргийг судлаад холбогдох харъяа гаалийн хороо, газарт хүргүүлэн ажиллав.</li> <li>- 2015 оны ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийн батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний дагуу уул уурхайн гаралтай экспортлох бүтээгдэхүүний тоо хэмжээний судалгааг хийв.</li> <li>- Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын дарга, Монгол улсын Гаалийн ерөнхий газрын даргын хамтран баталсан 2007 оны 471/816 дугаар тушаалын дагуу бэлтгэсэн мэдээллийг 2015.05.19-ний өдрийн 5/3786 тоот албан бичгээр Гаалийн ерөнхий газарт хүргүүлэв..</li> </ul>	
<p><b>2.7. Ашигт малтмалын тухай хуулийн стратегийн ач холбогдол бүхий ордын тодорхойлолтыг судалгаанд үндэслэн боловсронгуй болгосны үндсэн дээр стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын жагсаалтыг шинэчлэн батлуулна. /ЗГҮАМХ – 43.1 заалт/</b></p>			

<p>2.7.1. Шаардлагатай судалгаа хийж, холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах.</p>	<p>Тоо - шаардлагатай тоо хэмжээгээр, 1 санал Чанар - Бодитой, үндэслэл сайтай, хууль, журмын дагуу Хугацаа: 1-4 улиралд</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Үндсэн хуулийн цэцээс 2015 оны 2 дугаар сарын 10-нд ирүүлсэн хүсэлтийн дагуу “Цагаан суваргын ордын төрийн эзэмшлийн тухай” УИХ-ын 2014 оны 54 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардлагатай судалгаа хийж санал боловсруулан УУЯ-аас байгуулсан ажлын хэсэгт хүргүүлсэн.</li> <li>2. Гацууртын алтны үндсэн ордыг стратегийн ордод хамруулах асуудал УИХ-ын Эдийн засгийн байнгын хороогоор дэмжигдэн УИХ-аар хэлэлцэгдэх болсонтой холбоотой эдийн засгийн нэмэлт тооцоо, судалгаа хийж, мэдээлэл бэлтгэн Уул уурхайн яаманд ажлын шугамаар өгөв.</li> <li>3. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын талбайн хил заагийг тогтоох шалгуур үзүүлэлтийг боловсруулах, талбайн хил заагийг мэргэжлийн байгууллагаар тогтоолгох үүрэг бүхий ажлын хэсэгт хил зааг тогтоох аргачлалын төслийг хүргүүлэв.</li> <li>4. Дээрх асуудлаар Ашигт малтмалын газраас хүргүүлсэн албан бичгүүдийн хуулбарыг ажлын хэсгийн хуралд зориулан ажлын хэсгийн гишүүн С.Энх-Очирт өгөв.</li> <li>5. Монгол улсын Их Хурлын 2015 оны 1 сарын 23-ны өдрийн 11 дугаар тогтоолоор 2007 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн “Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай” 27 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын 16 дахь заалтанд Гацууртын ордын хил хязгаарыг нарийвчлан тогтоож, ордыг иж бүрнээр нь ашиглахаар нэмэлт оруулснаар стратегийн ордын жагсаалт нэгээр нэмэгдсэн.</li> </ol>	
<p><b>2.8. Стратегийн ач холбогдол бүхий ордын төрийн эзэмшлийг нэгтгэн, корпорацийн зохион байгуулалтад оруулна. /ЗГҮАМХ – 43.2-р заалт/</b></p>			
<p>2.8.1. Корпорацийн зохион байгуулалтад оруулахтай холбоотойгоор Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудын судалгааг баяжуулах. Холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах</p>	<p>Тоо- шаардлагатай тоо хэмжээгээр Чанар- Бодитой, үндэслэл сайтай, хууль, журмын дагуу Хугацаа: 1-4 улиралд</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Уул уурхайн сайдын 2014 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 1 дүгээр тушаалаар байгуулагдсан Уул уурхайн яам, Ашигт малтмалын газар, Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яамны төлөөлөл бүхий “Стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын зарим ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох” ажлын хэсэгт орж ажиллан, Цагаан суврагын ордын 23%-ийг төр үнэгүй эзэмших, ашигт малтмалын нөөц ашигласны татварын нэмэлт хувь тогтоох санал боловсруулан Засгийн газарт өргөн барьсан.</li> <li>2. Төмөртийн овооны орд, тогтвортой байдлын гэрээний</li> </ol>	

		<p>биелэлтийн талаарх мэдээллийг шинэчлэв.</p> <p>3. Монгол улсын Үндсэн хуулийн цэцийн Цагаан суваргын ордын талаарх 2015.2.10-ны өдрийн 3/54 тоот албан бичгийн хариуг боловсруулан 2015.2.27-ны өдрийн 1/1154 тоотой хариу явуулав.</p> <p>4. Гацууртын алтны үндсэн ордын эдийн засгийн болон өөрийн өртгийн тооцоог адил төстэй Олон овоот, Баян-айраг, Бороогийн алтны үндсэн ордуудтай харьцуулан өнөөгийн ханшид шилжүүлэн тооцсон судалгаа хийж ажлын хэсэгт танилцуулав.</p> <p>5. Гацуурт, Бороогийн ТЭЗҮ-тэй танилцан, холбогдох мэдээллүүдийг нэгтгэн судалгаа хийв.</p> <p>6. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудын судалгааг баяжуулах ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Гацуурт, Бороо, Асгат, Бүрэнхаан, Цагаан суварга, Эрдэнэтийн овоо, Төмөртэй, Төмөртийн овооны ордын мэдээллийг шаардлагатай тоо хэмжээгээр шинэчлэв.</li> <li>• Стратегийн 3 нүүрсний ордын хувь эзэмшил, хувьцааны талаарх мэдээллээр баяжуулав.</li> <li>• Стратегийн 16 ордын шаардлагатай болон татсан хөрөнгө оруулалтын мэдээллийг нэгтгэв.</li> <li>• Гадаад, дотоодын хөрөнгийн биржид гаргасан хувьцааны мэдээллийг шинэчлэв.</li> </ul> <p>7. Бороогоулд ХХК-ийн Бороогийн ордын танилцуулгад шинээр бүртгэсэн болон үлдэгдэл нөөц, 2013, 2014 онуудын тайлангийн өгөгдлүүд болон компанитай холбогдон улс, орон нутгийн төсөвт оруулсан төлбөр, татвар, шимтгэл, олборлосон хүдэр, бүтээгдэхүүн, экспортолсон бүтээгдэхүүний мэдээллийг цахимаар авч мэдээллийг шинэчлэв. Компаниас авсан мэдээлэл манайд байгаа тайлангийн мэдээллүүд зөрж байгаа учир харьцуулалт хийв.</p>	
<p><b>2.9. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зохицуулах журмын хэрэгжилтийг хангах, дүрэм, заавар, зааварчилгааг сурталчлах ажлыг зохион байгуулах.</b> /УХЦБ – 2.1.1; ЗГҮАМХ-45.1-р заалт/</p>			
<p>2.9.1. Бичил уурхайн гаралтай бүтээгдэхүүний борлуулалтыг ил тод болгох механизмыг бүрдүүлэхэд чиглэсэн судалгааг баяжуулж, цаашид авах арга</p>	<p>Тоо хэмжээ – Судалгааны ажлын 1 дүгнэлт Хугацаа – жилдээ</p>	<p>Судалгааны ажил хийгдэж, бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааны болон талбайн талаархи мэдээллийг УУЯ-ны мэргэжилтэн н.Наран-Эрдэнэд 6 дугаар сарын 23-нд <a href="mailto:nananerdene@mm.gov.mn">nananerdene@mm.gov.mn</a> хаягаар хүргүүлсэн.</p>	



хэмжээний санал боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлэх.	Чанар -Үнэн зөв, үндэслэл сайтай		
2.9.2. Хууль, журамд нийцүүлэн холбогдох алба, хэлтсийн саналыг авч Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талбайн дүгнэлт гаргах, талбайн мэдээллийг нэгдсэн санд бүртгэх, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах.	Тоо хэмжээ – Ирүүлэх хүсэлтийн тоогоор Хугацаа – Тухай бүр Чанар – Хууль журмын дагуу үнэн бодитой, тавигдах шаардлагад нийцсэн байна	<p>1. Бичил уурхайн талбайн дүгнэлт гаргуулахаар хүсэлт ирүүлсэн 7 аймгийн 23 сумын Засаг дарга нарт хариу албан бичиг төлөвлөн хүргүүлэв.</p> <p>2. ШХА-ын Тогтвортой бичил уурхай төсөлтэй хамтран ArcGIS программд суурилсан Монгол улсын газрын зураг дээр бичил уурхайн зориулалтаар дүгнэлт гарсан 16 аймаг, 32 сум, 84 талбай, 1546.36 га талбайн булангийн цэгийн солбилцол, ашигт малтмалын төрөл, нөхөрлөлийн тоо байршил, болон бусад тэмдэг тэмдэглэгээг байр зүйн тойм зураг хэлбэрээр оруулав.</p> <p>3. Бичил уурхайн талбайн дүгнэлтийн тойрох хуудсыг Ашигт малтмалын тухай хуульд нийцүүлэн боловсруулж АМГ-ын даргын 2015 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн а-81 тоот тушаалаар батлуулав.</p> <p>Уг тушаалын хавсралтыг дараах сумдад хүргүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Баянхонгор аймгийн Шинэжинст сум</li> <li>• Баянхонгор аймгийн Өлзийт сум</li> <li>• Хэнтий аймгийн Дархан сум</li> <li>• Төв аймгийн Борнуур сум</li> <li>• Төв аймгийн Заамар сум</li> <li>• Хэнтий аймгийн Баян-Адарга сум</li> <li>• Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сум</li> </ul> <p>4. Бичил уурхайн талбайн талаархи мэдээллийг санд нэгтгэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• 2015.5.16-23-ны өдрүүдэд Баян-Өлгий аймгийн Улаанхус суманд албан томилолтоор ажиллаж тус суманд үйл ажиллагаа явуулж буй бичил уурхайн талбай.</li> <li>• 2015.10.30-11.15-ны өдрүүдэд Бичил уурхайг хэрхэн зохион байгуулан ажиллаж байгаа талаар мэдээлэл авах, санал солилцох, хэрэгжилтийг хангуулах зорилгоор Төв аймгийн Сэргэлэн суманд 2, Эрдэнэ суманд 1, Улаанбаатар хотын Багахангай дүүрэгт 1, Хэнтий аймгийн Батноров суманд 9, Баян-Адарга суманд 4, Дархан суманд 5, Норовлин суманд 1, Дорноговь аймгийн Айраг суманд 6, Иххэт суманд 3, Дорнод аймгийн Баянтүмэн суманд 1, Дундговь аймгийн Баянжаргалан</li> </ul>	

		суманд 6, Гурвансайхан суманд 1, Өлзийт суманд 1, Хулд суманд 1, Дэлгэрхангай суманд 1, Луус суманд 3 талбай нийт 47 нэгж талбай.	
2.9.3. Бичил уурхай, ХАМО-ын байрзүйн тойм зураг, боловсруулан гаргах.	Тоо хэмжээ – 1 ажил үйлчилгээ Хугацаа – жилдээ Чанар –тавигдах шаардлагын дагуу	ШХА-ын Тогтвортой бичил уурхай төсөлтэй хамтран байр зүйн тойм зураг боловсруулах ажлын хүрээнд Улаанбаатар хотын Багануур дүүрэг, Ховд аймаг, Баян-Өлгий аймгийн Улаанхус сум, Төв аймгийн 2 сум, Хэнтий аймгийн 5 сум, Дорноговь аймгийн 2 сум, Дорнод аймгийн 1 сум, Дундговь аймгийн 6 суманд нийт 18 суманд албан томилолтоор ажиллаж бичил уурхайн үйл ажиллагааны болон талбайн мэдээ, мэдээллийг авсан. Мэдээллийг нэгтгэх ажлыг ШХА-ын тогтвортой бичил уурхай төслийн багтай хамтран боловсруулж зурган хэлбэрт шилжүүлэхээр ажиллаж байна.	
<b>2.10. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журамд орон нутгийн удирдлагын хүлээх хариуцлагыг тодорхой тусгаж, хэрэгжилтэд нь тавих хяналтыг сайжруулах чиглэлээр холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулна.</b>			
<b>/ЗГҮАМХ – 45.1-р заалт/</b>			
2.10.1. Хууль дүрэм, зааврыг мөрдөж ажиллах талаарх сургалт явуулах, сурталчилах, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах.	Тоо- шаардлагатай тоо хэмжээгээр Чанар- хууль, журмын дагуу, хүртээмжтэй Хугацаа: 1, 2-р улиралд	<ol style="list-style-type: none"> <li>1. АНУ-ын Азийн сангийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Байгаль орчныг нэмэгдүүлэхэд талуудын оролцоог нэмэгдүүлэх нь-II” төсөлтэй хамтран “Орон нутгийн түвшинд хариуцлагатай бичил уурхайг хэрэгжүүлэх хөшүүрэг, эсрэг тохиолдолд таслан зогсоох, хариуцлага тооцох арга замууд” сэдэвт бүсийн семинарыг 2015.4.8-11-ны өдрүүдэд хамтран зохион байгуулж оролцсон</li> <li>2. Увс аймгийн Тариалан, Өмнөговь сумдад 2015.05.12-17 өдрүүдэд албан томилолтоор ажиллаж АНУ-ын Азийн сантай хамтран нөхөн сэргээх талбай сонгох, сум орон нутгийн удирдлагуудад хууль, эрх зүйн мэдээллээр ханган ажиллав.</li> <li>3. Уул уурхайн сайдын ажлын хэсгийн бүрэлдхүүнд 2015.9.10-11-нд ажиллаж Сэлэнгэ аймгийн Мандал сум Дууч мандал ТББ-ын баяжуулах цех, Гацууртын ордтой газар дээр нь танилцаж ажлын хэсгийг холбогдох мэдээллээр хангаж ажиллав.</li> <li>4. Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо ТББ-аас Дорноговь аймгийн Айраг суманд 2015.9.18-19-ны өдрүүдэд зохион байгуулсан “Бичил уурхайн сайн туршлага – Хөгжлийн гарц” туршлага солилцох өдөрлөгт “Бичил уурхайн зохиулалт бүхий газрын асуудал” сэдвээр илтгэл тавьж оролцлоо.</li> <li>5. Санхүүгийн зохицуулах хорооноос Хэнтий аймгийн Чингис</li> </ol>	

		<p>хотод 2015.9.21-22-ны өдрүүдэд зохион байгуулсан “Санхүүгийн үйлчилгээний хүртээмж ба орон нутгийн хөгжил” сэдэвт чуулга уулзалтад “Бичил уурхайн нөхөрлөлийн өнөөгийн байдал хөгжлийн цаашдын хандлага” сэдвээр илтгэл тавьж оролцов.</p> <p>6. Ховд, Баян-Өлгий аймагт албан томилолтоор ажиллаж хууль, журмын хэрэгжилтийн талаар болон бичил уурхайн үйл ажиллагааны талаар сургалт зохион байгуулсан.</p> <p>7. Бичил уурхайн төсөлтэй хамтран “Бичил уурхайг албажуулах замаар бичил уурхайчдын нийгмийн хамгааллыг сайжруулах нь” сэдэвт Үндэсний чуулганыг 2015.12.03-ны өдөр хамтран зохион байгуулав.</p>	
<p>2.10.2. “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг шинэчлэн боловсруулан батлуулах, бичил уурхайн нөхөн сэргээлтийн зааварчилгааг төсөл хөтөлбөрүүдтэй хамтран боловсруулна.</p>	<p>Тоо- 1 журам, 1 зааварчилгаа Чанар- хууль, журмын дагуу, хүртээмжтэй Хугацаа: 1, 2-р улиралд</p>	<ul style="list-style-type: none"> <li>- “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд Уул уурхайн сайдын 2015.02.25-ны өдрийн 34-р тушаалаар ажлын хэсэг байгуулагдан 3 удаа хэлэлцүүлэг зохион байгуулж оролцон саналыг нэгтгэн уул уурхайн яамны мэргэжилтэн н.Наран-Эрдэнэд цахим хэлбэрээр хүргүүлэн ажилласан.</li> <li>- АНУ-ын Азийн сангийн “Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь” II төслийн багтай хамтран “Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалыг боловсруулж дууссан.</li> <li>- Бичил уурхайг орон нутагт хэрхэн зохион байгуулж байгаа талаар мэдээлэл авах, санал солилцох, хууль, журмын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Төв аймгийн Сэргэлэн суманд 2, Эрдэнэ суманд 1, Улаанбаатар хотын Багахангай дүүрэгт 1, Хэнтий аймгийн Батноров суманд 9, Баян-Адарга суманд 4, Дархан суманд 5, Норовлин суманд 1, Дорноговь аймгийн Айраг суманд 6, Иххэт суманд 3, Дорнод аймгийн Баянтүмэн суманд 1, Дундговь аймгийн Баянжаргалан суманд 6, Гурвансайхан суманд 1, Өлзийт суманд 1, Хулд суманд 1, Дэлгэрхангай суманд 1, Луус суманд 3 нийт 46 нэгж талбай дээр 2015.10.30-11.15-ны өдрүүдэд албан томилолтоор ажиллаж хууль, журмын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авав.</li> </ul>	
<p>2.10.3. Бичил уурхайгаар олборлосон хүдрийг баяжуулахад ашиглаж буй “Баяжуулах цехэд тавигдах техникийн</p>	<p>Тоо- 1 ажил үйлчилгээ Чанар- хууль, журмын дагуу, хүртээмжтэй</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 308 дугаар тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 12.2, 12.3-д заасан “Баяжуулах цехэд</li> </ul>	

нөхцөл"-ийн төслийг боловсруулах, батлуулах арга хэмжээ авах.	Хугацаа: 1, 2-р улиралд	тавигдах техникийн нөхцөл"-ийг судлах, үнэлэлт дүгнэлт өгөх ажлын хүрээнд хийж гүйцэтгэвэл зохих ажлын хуваарь, дараалал, бүрэлдэхүүн, томилолтын удирдамж зэргийг боловсруулав.	
<b>2.12. “Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх санаачилга”-ын зарчим, стандартыг төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ. /ЗГҮАМХ – 46.2-р заалт/</b>			
2.12.1. “Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх санаачилга”-ын зарчим, стандартыг хэрэгжүүлэн ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудыг шаардлагатай мэдээллээр хангаж ажиллана.	Тоо- шаардлагатай тоо хэмжээгээр, Чанар- хууль, журмын дагуу Хугацаа: 1, 2, 3, 4-р улиралд	Холбогдох байгууллагуудыг шаардлагатай мэдээллээр хангаж байна. Энэ ажлын хүрээнд: - Эрдэс баялгийн салбарын талаарх орон нутгийн иргэдийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, дэд зөвлөлийн үйл ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Зуунмод хотод зохион байгуулсан ОУИТБС-ын өдөрлөгт оролцон, Төв аймгийн нэр бүхий 5 сумдын тусгай зөвшөөрөл, тайлан өгсөн байдал болон хайгуулын тусгай зөвшөөрөл олгох зааврын талаар powerpoint программаар мэдээлэл бэлтгэн, танилцуулав. - Эрдэс баялгийн салбарын талаархи орон нутгийн иргэдийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, дэд зөвлөлийн үйл ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Сэлэнгэ хотод зохион байгуулах ОУИТБС-ын өдөрлөгт зориулан, Сэлэнгэ, Булган, Орхон, Дархан-Уул аймгуудын тусгай зөвшөөрөл, уулын ажлын тайлан өгсөн байдал болон хайгуулын тусгай зөвшөөрөл олгох зааврын талаар powerpoint программаар мэдээлэл бэлтгэж, илтгэл тавив. - ОУИТБС-ын тайланг хэрхэн гаргах талаар ААН-үүдэд 2015.03.04-ний өдөр сургалт явуулж тайлан гаргахад гардаг нийтдэг алдааны талаар танилцуулав. Нийт оролцогчдоос хайгуулын тайлангийн 10-р маягыг бөглөх талаар заавар зөвлөлгөө өгөх, сургалт зохион байгуулах, АМГ-т зөвлөгөө өгдөг хэлтэстэй болгох талаар чиглэл өгч ажилласан. - Ерөнхийлөгчийн Тамгын газар, ҮАБЗ-өөс хамтран зохион байгуулсан “Хариуцлагатай уул уурхай-иж бүрэн ашиглалт, уурхайн хаалт, нөхөн сэргээлт” сэдэвт хэлэлцүүлэгийг мэдээллээр ханган, хэлэлцүүлэгт 11 сарын 20-ны өдөр оролцож, санал хэлэв.	
<b>2.13. Засгийн газраас баталсан хил хязгаарын дагуу “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллана.</b>			

<p>2.13.1. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, олборлох, ашиглахыг хориглох тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой судалгаа, мэдээллээр хангаж ажиллах.</p>	<p>Тоо-шаардлагатай тоо хэмжээгээр Чанар- Үнэн зөв, цаг хугацаандаа багтсан байх. Хугацаа-1,2,3,4 улиралд</p>	<p>1. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, олборлох, ашиглахыг хориглох тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэгт орж ажиллан шаардлагатай судалгаа, мэдээлэл бэлтгэж өгсөн. Тус хууль нь 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар батлагдсан.</p> <p>1. “Гол мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам” - ыг үндэслэн “Өргөдөл хүлээн авах, гэрээ байгуулахтай холбогдох арга хэмжээ авах дотоод заавар”, “Хяналтын хуудасны загварыг АМГ-ын даргын 2015 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн а/75 дугаартай тушаалаар батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>2. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн дагуу ирүүлэх өргөдлийн маягт боловсруулж байгууллагын цахим хуудсанд байршуулсан. Нийт 360 тусгай зөвшөөрөл дээр өргөдөл ирүүлсэн байна.</p> <p>3. БОНХАЖЯ-наас гаргасан 488, Засгийн газрын 174 дүгээр тогтоолд хамрагдсан 242, Засгийн газрын 194 дүгээр тогтоолд хамрагдсан 422 ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, судалгаа хийн, бүртгэл хөтлөв.</p> <p>4. Эдгээр 488 ашиглалтын тусгай зөвшөөрлүүд хэрхэн давхцаж байгаа талаар судалгаа хийж, Засгийн газрын 174, 194 дүгээр тогтоолд хамрагдаагүй 140 ашиглалтын тусгай зөвшөөрлийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар санал бэлтгэж хэлэлцүүлэв.</p> <p>5. 2015.05.29-ны өдөр БОНХАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга болон УУЯ, Ашигт малтмалын газрын хамтарсан уулзалтад Засгийн газрын 2015 оны 120 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар танилцуулж, Засгийн газрын 174, 194 дүгээр тогтоолд хамрагдаагүй боловч БОНХАЖЯ-наас нэмэлтээр оруулсан 140</p>
---	---	--

		<p>ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийн үйлчлэлд хамруулсан тухай, түүнийг хэрхэн яаж зохицуулах тухай хэлэлцүүлж, журмын дагуу шийдвэрлэх талаар чиглэл өгсөн</p> <p>6. БОНХАЖЯ-наас хуульд нэмж хамруулсан 140 ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн судлагааг мэдээллийн нэгдсэн санд нэмэн мэдээллийг баяжуулж байна.</p> <p>7. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн дагуу өргөдөл хүлээн авах зарыг байгууллагын вэб хуудсанд байршуулж, “Өнөөдөр”, “Өдрийн сонин”, “Монголын мэдээ” сонингуудын 2015.06.11-ний өдрийн дугаарт нийтлүүлэв.</p> <p>8. Ашигт малтмалын дарга Д.Үүрийнтуяагийн өгсөн үүрэг даалгаврын дагуу ЗГ-ын 174 дүгээр тогтоолд хамрагдаж, тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн хүсэлтийг нэгтгэн, хуулийн хэлтэст шилжүүлэв.</p> <p>9. Гол, мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журмын 2.1 дэх заалтын дагуу 657 ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч өргөдөл ирүүлэхээс нийт 218 өргөдөл хүлээн авч бүртгэв.</p> <p>10. Засгийн газрын 174 дүгээр тогтоолд хамрагдаж нөхөх олговор авах хүсэлт ирүүлсэн 124 тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн судалгаа гаргаж, санал боловсруулж Ашигт малтмалын газрын дэд дарга С.Амарсайханд танилцуулсан.</p> <p>11. Өргөдөл ирүүлээгүй 143 тусгай зөвшөөрөл эзэмшигч 93 аж ахуйн нэгжийн удирдлагын утас руу залгасан боловч 75 аж ахуйн нэгжтэй холбогдож өргөдлөө хуулийн хугацаанд ирүүлэх талаар мэдэгдсэн.</p> <p>12. Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүстэй давхцалтай 97 ашиглалтын тусгай зөвшөөрлийн жагсаалт гаргаж</p>	
--	--	---	--

	<p>дүгнэлт гаргуулахаар ажиллаж байна.</p> <p>13. Энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж байсан талаар дүгнэлт гаргуулах 16 тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс шаардлагатай материалуудыг хүлээн аваад байна</p> <p>14. Урт нэртэй хуульд хамрагдсан алтны тусгай зөвшөөрлийн нөөц болон давхцалын судалгаа гаргаж Уул уурхайн яаманд ажлын шугамаар хүргүүлсэн.</p> <p>15. БОНХАЖЯ-наас лавлагаа ирүүлээгүй 129 тусгай зөвшөөрлийг хориглосон талбайтай хэрхэн давхцаж байгаа талаар Кадастрын системээс шүүлт хийж, мэдээллийн сангийн бүртгэлд оруулав.</p> <p>16. Хууль батлагдахаас өмнө үйл ажиллагаа явуулж байсан аж ахуйн нэгжүүдийн судалгааг гаргав.</p> <p>17. АМГ-ын даргын 2015 оны 6 сарын 15-ны өдрийн а/58 тушаалаар батлагдсан "Глиймстар", "Шижир-Алт" ХХК-иудын 1866А, "Илтгоулд" ХХК-ийн 15424А тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг шилжүүлэх болон нөхөх олговрыг тэг төгрөгөөр тооцож цуцлахтай холбоотой шийдвэрүүд холбогдох хууль, журамд нийцэж байгаа эсэхэд дүгнэлт гаргах ажлын хэсэгт ажиллаж холбогдох мэдээллээр ханган асуудлуудыг судалж санал, дүгнэлт гарган ажиллаа.</p> <p>18. УУЯ-аас чиглэл, БОНХАЖЯ, МХЕГ-аас мэдээлэл авч Усны сан бүхий газрын энгийн хамгаалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээх үйл ажиллагааны гэрээний төслийг боловсруулан 3 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулах ажлыг зохион байгуулав.</p> <p>19. БОНХАЖЯ-аас усны сан бүхий газрын энгийн хамгаалтын бүсэд үйл ажиллагаа явуулсан 26 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн талбайд хамрагдах онцгой хамгаалтын бүсийн хилийн зураг, солбицлыг авч Кадастрийн хэлтэст хүлээлгэн өгөв.</p> <p>20. АМГ-ын даргын 2015 оны 6 сарын 15-ны өдрийн а/58 тушаалаар батлагдсан "Глиймстар", "Шижир-Алт" ХХК-иудын 1866А, "Илтгоулд" ХХК-ийн 15424А тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг шилжүүлэх болон нөхөх олговрыг тэг төгрөгөөр тооцож цуцлахтай холбоотой шийдвэрүүд холбогдох хууль, журамд нийцэж байгаа эсэхэд дүгнэлт гаргах ажлын хэсэгт</p>
--	---

		<p>ажиллаж асуудлуудыг судалж дүгнэлт гаргахад санал өгч ажиллаа.</p> <p><i>Мэдээллээр хангаж ажилласан:</i></p> <p>1. Давхардсан тоогоор 127 тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль”, Засгийн газрын 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан 120 дугаар тогтоолын талаар мэдээллээр хангаж ажилласан.</p> <p>2. Ашигт малтмалын газрын дэд дарга С.Амарсайханаар ахлуулсан Засгийн газрын 289 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хэсгийн хуралд 3 удаа оролцож танилцуулга хийж, санал танилцуулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Энгийн болон онцгой хамгаалалтын бүстэй давхцалтай 119 тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жил бүрийн уулын ажлын тайланг ГМТ-өөс 105 хавтас мэдээллээс шүүлт хийж 516 ширхэг уулын ажлын дэвсгэр зураг, батлагдсан нүүр, нөөцийн хөдөлгөөнийг скайнердаж файл үүсгэлээ.</li> <li>- Шүүлт хийгдсэн 313 уулын ажлын дэвсгэр зургуудыг тусгай зөвшөөрлийн талбайн хил, энгийн хамгаалалтын бүсийн 200 метртэй ArcGis 9.0 программд давхцуулалт хийлээ.</li> </ul>	
<p><b>2.14. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулсан хохирлын үнэлгээг хийж, олон улсын стандартын дагуу нөхөн сэргээлт хийх зардлын тооцоог тусгай зөвшөөрөл бүрт тооцож хэрэгжүүлнэ.</b></p> <p><b>/ЗГҮАХХАХТ-47.2 заалт/</b></p>			
<p>2.14.1. Хохирлын үнэлгээ хийлгэх шаардлагатай тусгай зөвшөөрлийн судалгааг боловсронгуй болгон холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах.</p>	<p>Тоо- шаардлагатай тоо хэмжээгээр, Чанар- хууль, журмын дагуу Хугацаа: 1, 2, 3, 4-р улиралд</p>	-	
<p><b>2.15. Экспортод гаргаж байгаа уул уурхайн бүтээгдэхүүний стандартыг олон улсын жишигт нийцүүлэх талаар судалгаа хийж хэрэгжүүлнэ.</b></p> <p><b>/ЗГҮАХХАХТ-49.1 заалт/</b></p>			
<p>2.15.1. Экспортод гаргаж байгаа уул уурхайн бүтээгдэхүүнүүдийн гадаадын</p>	<p>Тоо- 2 судалгаа Чанар- хууль, журмын</p>	<p>1. 2012–2014 онуудад экспортолсон Уул уурхайн бүтээгдэхүүнүүдийн нэр төрөл, тоо хэмжээгээр судалгаа хийн,</p>	



болон дотоодын стандартын судалгааг хийнэ.	дагуу Хугацаа: 1, 2-р улиралд	мэдээллийг гаргав. 2. Экспортод гаргаж байгаа уул уурхайн бүтээгдэхүүний (Cu, Fe, CaF <sub>2</sub> , Mo, WO <sub>3</sub> , Pb, Zn,) жагсаалтыг гаргаж, мэдээллийг нэгтгэсэн. 2015 оны 09 дүгээр сарын байдлаар Монгол улсын уул уурхай, ашигт малтмалтай холбоотой хүчин төгөлдөр 332 ширхэг стандартуудын жагсаалтыг нэр төрлөөр нь ангилав. Экспортод гаргаж байгаа уул уурхайн бүтээгдэхүүний MNS стандартуудын судалгааг гаргав.	
2.15.2. Гадаад болон дотоодын стандартуудын судалгаануудыг харьцуулж, санал боловсруулж УУЯ-нд хүргүүлнэ.	Тоо- 1 санал Чанар- хууль, журмын дагуу Хугацаа: 3, 4-р улиралд	ОХУ-ын ГОСТ, СЭВ (ГОСТ 52998-2008, ГОСТ 4421-73, ГОСТ 29219-91, ГОСТ 29220-91, ГОСТ 52939-2008), БНХАУ-ын VBT (VBT 5217-2005) зэрэг стандартуудыг орчуулах ажлыг хийж байна.	
<b>2.16. Экспортод гаргаж байгаа бүрэн боловсруулаагүй хүдэр харгалзан экспортын татвар ногдуулах эрх зүйн орчинг бүрдүүлнэ. /ЗГҮАМХ – 49.5-р заалт/</b>		<b>болон баяжмалыг боловсруулалтын түвшинг нь</b>	
2.16.1. Экспортод гаргаж байгаа бүрэн боловсруулаагүй хүдэр болон баяжмалын боловсруулалтын түвшинг нь харгалзан олон улсын экспортын татварын судалгааны ажил хийнэ.	Тоо- 1 санал, 2 арга хэмжээ Чанар- Үндэслэл сайтай, хэрэгжихүйц бодитой Хугацаа: 1, 2, 3 улиралд	Экспортод гаргаж байгаа бүрэн боловсруулаагүй хүдэр болон баяжмалын боловсруулалтын түвшинг тодорхойлж, харгалзан олон улсын экспортын татварын судалгааг хийлээ.	
<b>2.17. Эвдрэлд орж эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх санхүүжилтийн асуудлын эрх зүйн орчныг бий болгож, нөхөн сэргээлт хийсэн газрын мэдээллийн нэгдсэн санг бий болгоно. /ҮХЦБ–5.2.1.1; ЗГҮАМХ – 54.2-р заалт/</b>			
2.17.1. Нөхөн сэргээлт хийгдсэн газрын мэдээллийг нэгдсэн санд нэгтгэх, санг хөтлөх, баяжуулах, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах.	Тоо- шаардлагатай тоо хэмжээгээр Чанар- хууль, журмын дагуу Хугацаа: 1, 2,3,4-р улиралд	- 2014 оны уулын ажлын төлөвлөгөөнөөс нөхөн сэргээлт хийсэн 45 аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг (эвдрэлд орсон талбай, техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай) авч, мэдээллийн санд нэгтгэсэн. - “Газрын тос, ашигт малтмалын нөөц ашигласны болон байгаль орчныг бохирдуулсны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээний тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт орж ажиллав. 6 удаагийн хэлэлцүүлэгт оролцон уулын ажлын төлөвлөгөө тайлангаар ирүүлсэн эвдрэлд орсон талбайн хэмжээ болон нөхөн сэргээлтийн явцын талаар мэдээлэл хүргүүлэн ажиллаа. - Нөхөн сэргээлт хийсэн аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг авч	

		газрын мэдээллийн санд нэгтгэн баяжуулж холбогдох ажлын хэсэг болон байгууллагыг мэдээллээр хангана ажилласан. Мэдээллийг БОАЖНХЯ-ны Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дэргэдэх Байгаль орчны мэдээллийн санд mtt@majicnet.mn цахим хаягаар хүргүүлээ.	
<b>2.18. Геологийн хувьд нэгдмэл тогтоцтой, ордуудын тусгай зөвшөөрлийг хэсэгчилж олгохгүй байх асуудлыг шийдвэрлэнэ. /ЗГҮАМХ-40.16-р заалт/</b>			
2.18.1. Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд санал өгнө.	Тоо- 1 санал Чанар- Үндэслэл сайтай Хугацаа: 1-4 улиралд	Ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн орд нөөцтэй эсэхэд хяналт тавих явцад 15 ашиглалт хүссэн өргөдлийн талбай хэт том байсанд тайлбар гаргуулан судалгаа хийсэн ба 3 орд нэгдмэл тогтоцтой тул судалж тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс өргөдлийн талбайд ноогдох нөөцийг эрх бүхий байгууллагаар дахин тооцоолуулан баталгаажуулсан. Дээрх судалгаанд тулгуурлан Ашигт малтмалын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай санал боловсруулан, УУЯ-нд 2015 оны 12 дугаар сард багтаан албан тоотой хүргүүлэхээр бэлтгээд байна.	
<b>2.20. Уулын үйлдвэрийн үзүүлэлтүүдийг мэдээллийн санд нэгтгэх, нөөцийн бүртгэл хөтлөх</b>			
2.20.1. Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны 2015 болон 2016 оны төлөвлөгөөг аж ахуйн нэгжүүдээс хүлээн авч хянан үндсэн үзүүлэлтүүдийг мэдээллийн санд нэгтгэх.	Тоо хэмжээ – 2 арга хэмжээ Хугацаа - Тухай бүр Чанар -Хамтын ажиллагаа үр дүнтэй, санал үндэслэл сайтай хэрэгжихүйц байна	1. Уулын болон баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийн 2015 оны ашиглалтын үйл ажиллагааны 388ш уулын ажлын төлөвлөгөөг ААН-үүдээс хүлээн авснаас 323ш уулын ажлын төлөвлөгөөг хянаж зөвшөөрөн үндсэн үзүүлэлтүүдийг мэдээллийн санд нэгтгэлээ. 2. Уулын болон баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийн 2016 оны ашиглалтын үйл ажиллагааны 275 уулын ажлын төлөвлөгөөг ААН-үүдээс хүлээн авснаас 25 уулын ажлын төлөвлөгөөг хянаж зөвшөөрөн үндсэн үзүүлэлтүүдийг мэдээллийн санд нэгтгэлээ.	
2.20.2. Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны 2014 оны тайланг аж ахуйн нэгжүүдээс хүлээн авч хянан үндсэн үзүүлэлтүүдийг мэдээллийн санд нэгтгэх.	Тоо хэмжээ – 1 арга хэмжээ Хугацаа - Тухай бүр Чанар –Үнэн бодитой, шуурхай	1. Уулын болон баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийн 2014 оны ашиглалтын үйл ажиллагааны 215ш уулын ажлын тайланг ААН-үүдээс хүлээн авснаас 171ш уулын ажлын тайланг хянаж зөвшөөрөн үндсэн үзүүлэлтүүдийг мэдээллийн санд нэгтгэлээ. 2. Үйл ажиллагаа явуулаагүй тухай албан тоот 2014 онд 111, 2015 онд 16 тусгай зөвшөөрөл эзэмшигч ирүүлснийг хүлээн авч мэдээллийн санд нэгтгэсэн.	

		3. Үйл ажиллагааны төлөвлөгөө хүргүүлэх боломжгүй тухай албан тоотыг 2015 онд 187, 2016 онд 87 аж ахуйн нэгж ирүүлснийг хүлээн авч мэдээллийн санд нэгтгэсэн.	
2.20.3. 2014 онд олборлолт явуулсан металл болон металл бус ордуудын ашигт малтмалын нөөцийн хөдөлгөөний тоо бүртгэлийг хөтлөн нөөцийн хөдөлгөөний саналыг ЭБМЗ-д хүргүүлэх.	Тоо хэмжээ – 1 санал Хугацаа - Тухай бүр Чанар - Үндэслэл сайтай хэрэгжихүйц байна	1. Алтандорнод ХХК-ийн MV-000290 тоот тусгай зөвшөөрлийн талбайд ноогдох нөөцийн хөдөлгөөний зөрүүг судалж 2007-2008 оны нөөцийн хөдөлгөөнөөс дутсан 126.6кг алтыг нөөцийн нэмэлт тодотголын дүгнэлтэнд нэмж оруулах шийдвэрийг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. 2. Цемент шохой ХХК-ийн MV-012219, MV-015249 тоот тусгай зөвшөөрлүүдийн талбай дахь батлагдсан нөөц ашиглалтын үед батлагдахгүй 40 хүртэл хувиар буурч байгаа үндэслэлийг тогтоон ЭБМЗ-ийн дүгтэлт гаруулахаар шилжүүлсэн. 3. Монголросцветмет ХХК-ийн MV- 000175 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай дахь алтны үлдэгдэл нөөц 827.48кг-аар дутсан байгааг тогтоон ЭБМЗ- ийн дүгнэлт гаруулахаар шилжүүлсэн. 4. 2014 онд үйл ажиллагаа явуулсан 74 тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийн хөдөлгөөний бүртгэл хийсэн. 5. Үйл ажиллагаа явуулж буй металл бус ашигт малтмалын нөөцийн үлдэгдэл гаргаж удирдлагад танилцуулсан.	
